МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

ЗӨВ ЗҮГТ МАНЛАЙЛНА

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2025

02-Р САР

www.mnca.mn

МБҮА

МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

SINCE 2009

Зөв зүгт Манлайлна

ОРШИЛ

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь өөрийн байгууллагын Эрхэм зорилго, зорилтын хүрээнд зах зээлийн эдийн засгийн үндсэн зарчимд нийцсэн барилгын салбарын тогтвортой байдлыг хангах, засаглалын зөв тогтолцоог бий болгох, салбарын эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангасан урт, богино хугацааны бодлогын болон стратегийн бичиг баримтыг боловсруулахад нөлөөлөх, суурь судалгааг хийх, салбарын чадавхыг сайжруулах чиглэлд салбарын яам, холбоод, иргэний нийгэм, гадаадын төсөл, хөтөлбөр болон олон улсын байгууллагуудтай үйл ажиллагаагаа өргөжүүлэн олон талаар хамтран ажилладаг билээ.

Дээрх эрхэм зорилго, зорилтын хүрээнд МБҮА ТББ-ын Ажлын алба нь 2025 оны 02 дугаар сард хийж гүйцэтгэсэн ажил, арга хэмжээ, үйл ажиллагааныхаа тайланг товхимол хэлбэрээр бэлтгэн хүргэж байна.

ОЛОН НИЙТЭД ЗОРИУЛСАН ТАЙЛАН

2025

АГУУЛГА



1. ЗАХИРГАА УДИРДЛАГА
2. БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГАА
3. СУРГАЛТ, ХӨГЖИЛ
4. ГИШҮҮНЧЛЭЛ ХАМТЫН АЖИЛЛАГАА
5. БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
6. ДУЛААН ШИЙДЭЛ ТӨСӨЛ-2

2025




ЗАХИРГАА-УДИРДЛАГА

Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ нь 2009 онд үүсгэн байгуулагдаж, өөрийн эгнээндээ барилга, бүтээн байгуулалтын салбарт идэвхтэй үйл ажиллагаагаа явуулдаг томоохон хөрөнгө оруулагч, хөгжүүлэгч, үл хөдлөх хөрөнгийн реалтор, барилга угсралт, барилгын материалын үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч, архитектур, зураг төслийн чиглэлийн 160 гаруй гишүүн компаниудын бүтээн байгуулагчдыг сайн дурын үндсэн дээр нэгтгэж, гишүүддээ болон нийгэмдээ үйлчлэхээс гадна төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэдэг салбарын мэргэжлийн, манлайлагч, үндэсний бүтээн байгуулагчдын хамгийн том нэгдэл болох төрийн бус байгууллага юм. МБҮА ТББ нь Азийн ба Баруун Номхон Далайн Гэрээлэгчдийн Ассоциациудын Олон Улсын Нийгэмлэг (IFAWPCA)-ийн “УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН”, Олон Улсын Зөвлөх Инженерүүдийн холбоо (FIDIC)-ны “ТҮНШЛЭГЧ ГИШҮҮН”, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим (МҮХАҮТ)-ын УДИРДАХ ЗӨВЛӨЛ БОЛОН ТЭРГҮҮЛЭГЧ ГИШҮҮН” байгууллага юм.

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР 15141,
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 5-Р ХОРОО, САМБУУГИЙН ГУДАМЖ
МН ТАУЭР, 8-Р ДАВХАР
WWW.MNCA.MN

МБҮА ТББ-ЫН УДИРДЛАГУУД УИХ-ЫН ГИШҮҮН Г.ЛУВСАНЖАМЦТАЙ САНАЛ СОЛИЛЦЛОО



МБҮА ТББ-ын Дэд ерөнхийлөгч, Ультрасоник ХХК-ийн захирал Б.Чимэгцэцэг, НБИК ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Баяраа, Гүйцэтгэх захирал Г.Батсүх нар 2025.02.04 өдөр Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамцтай барилгын салбарт тулгамдаж буй асуудал, барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг олгох үйл явц, тавигдаж буй шаардлага, нөхцөл, түүнийг сайжруулахаар “Ажлын хэсэг” хэрхэн ажиллаж буй талаарх мэдээлэл болон ногоон барилга, ногоон технологийн талаар өнөөдөр баримталж буй бодлого, сайжруулалтын талаар санал солилцлоо. Уулзалтаар ирэх 2025.03-р сард Барилгын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн төлөөллүүдтэй зангиагүй уулзалтыг хийж салбарын өмнө тулгамдаж буй асуудлаар санал солилцохоор боллоо.

НИЙСЛЭЛИЙН УДИРДЛАГУУДАД БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН НИЙЛҮҮЛЭЛТ, ТЭЭВЭР, ЛОГИСТИКИЙН ТАЛААРХ ТӨСЛӨӨ ТАНИЛЦУУЛЛАА





Томоохон бүтээн байгуулалтууд эхэлж байгаа энэ үед МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч Н.Баярсайхан, Гүйцэтгэх захирал Г.Батсүх нь Монголын Ложистикийн холбоотой хамтран барилгын салбарын барилгын материал үйлдвэрлэл, нийлүүлэлтийн тээвэр, логистикийн сүлжээ, хууль эрх зүйн орчны өнөөгийн байдал болоод тулгарч байгаа асуудал, түүнийг хэрхэн шийдвэрлэх, боломж хаана байгаа вэ гэдэг талаарх төслийг Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, Хотын орлогч Т.Даваадалай, төслийн нэгжийн захирлуудад танилцуулж санал бодлоо солилцлоо.

МБҮА ТББ нь Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж, Монголын Логистикийн Холбоотой хамтран ажиллах санамж бичгийг байгуулан Гишүүн байгууллагуудтайгаа хамтран төсөл хөтөлбөрүүдэд оролцох, судалгаа хийх, төр, хувийн хэвшлийн түншлэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, үндэсний компани, үйл ажиллагаа эрхлэгчдийн эрх ашгийг бэхжүүлэх чиглэлээр харилцан санал бодлоо солилцож ойлголцолд хүрээд байгаа юм.

“БИ БАРИЛГАЧИН ХҮН” ЧУУЛГА УУЛЗАЛТАД МБҮА ТББ ОРОЛЦЛОО



Монгол Улсын хөгжлийг түргэтгэх эдийн засгийн арга хэрэгсэл болох бүсүүдийг тодорхойлж, бүсүүдэд эдийн засаг, санхүүгийн дэмжлэг, бизнесийн таатай орчныг бүрдүүлэх, орон зайн төлөвлөлт бүхий зорилтуудыг Засгийн газраас зарлан ажиллаж байгаа бөгөөд Баян-Өлгий аймгийн ИТХ-ын дарга, түүний баг хамт олон болон хамтран ажилласан ААН компаниудын дэмжлэгтэйгээр "Би барилгачин хүн" чуулга уулзалтыг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд МБҮА ТББ нь Түншлэгч байгууллагуудын хамт “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох” үйл ажиллагааны өнөөгийн явц, тулгамдаад байгаа асуудал, тусгай зөвшөөрлийн журам, суурь нөхцөл байдалд оруулж буй өөрчлөлт шинэчлэлтийн талаарх мэдээллийг орон нутгийн барилгын салбарынхан, аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл өглөө. Баян-Өлгий аймагт барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй 43 ААНБ үйл ажиллагаа явуулж байгаа ба орон сууцны м2-ын үнэ нь 2,800-3,000,000 сая төгрөгийн үнэ ханштай байна. Мөн Өлгий хотын дулааны шугам сүлжээ, түүний насжилт, хүрэлцээ хангамжийн асуудал болоод төрийн тендер худалдан авах ажиллагааг шударга болгох инженер, техникийн ажилтнуудыг мэргэшүүлэх, залуучуудыг барилгын мэргэжил эзэмшүүлэх, барилгын компанийг чадавхжуулахад хамтран ажиллах саналтай байгаагаа илэрхийлж байлаа.

Чуулга уулзалтад Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Сайдын орон тооны зөвлөх М. Ибрай ахлуулсан салбарын мэргэжлийн ТББ-ууд болох Барилгын хөгжлийн төв ТӨҮГ, Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ, Амины орон сууцны инновац хөгжлийн төв, Монголын Барилгын Инженерүүдийн Холбоо, Монголын барилгын зураг төсөл зохиогчдын холбоо зэрэг байгууллагууд оролцлоо.

МБҮА ТББ НЬ 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮДЭЭ УЗ-ИЙН ГИШҮҮДДЭЭ ТАНИЛЦУУЛЛАА



МБҮА ТББ нь дүрмийн дагуу үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөө, төсвийн зарцуулалтаа гишүүддээ танилцуулж ирэх онд хийгдэх төсөв, хөтөлбөр төсвөө УЗ-ийн Гишүүдээрээ батлуулдаг зарчмын дагуу 2025 оны ээлжит хурлаа зохион байгууллаа.
МБҮА ТББ нь уламжлалын дагуу хурлын өмнө шинэ гишүүн байгууллагуудаа Удирдах зөвлөлийн гишүүддээ танилцуулж, гэрчилгээг гардуулан Үндэсний хэмжээний том байгууллагад нэгдсэнд нь талархал илэрхийллээ. Хурлаар Гүйцэтгэх захирал Г.Батсүх тайлангаа танилцуулж 2025 онд хэрэгжүүлэх томоохон төсөл хөтөлбөрүүд болоод орон нутгийн

салбар зөвлөлтэй болох төлөвлөгөөний талаар боловсруулсан төслийн журмыг батлууллаа. Мөн ирэх онд МБҮА ТББ-ын дэргэд байгуулсан “Барилга дэд бүтцийн олон улсын Арбитр”, Олон Улсын Зөвлөх Инженерүүдийн Холбоо (FIDIC)-н түншлэгч гишүүний хүрээнд хийгдсэн болоод хийгдэх ажлуудын төлөвлөгөө, төсвийн танилцуулгыг Удирдах зөвлөлийн гишүүн, “Эс Ди Инженеринг энд Констракшн” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Баасансүрэн танилцуулж батлууллаа. Түүнээс гадна байгууллагын 2024 оны үйл ажиллагаа болоод санхүүгийн тайланг Хяналтын зөвлөлийн дарга С.Ганзориг танилцуулж мэдээлэл өглөө.

"СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТ БА ЭРХ ЗҮЙН ОРЧИН” НЭГДСЭН ХУРАЛДААНД БАРИЛГЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААР САНАЛ СОЛИЛЦЛОО

“Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль”-ийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэхтэй холбоотойгоор "СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТ БА ЭРХ ЗҮЙН ОРЧИН” нэгдсэн хуралдааныг Төрийн ордонд зохион байгуулсан ба тус хуралдааны үеэр МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх барилгын салбарын өмнө тулгамдаж буй асуудлын талаар асуудал дэвшүүллээ.





2025



САЛБАРЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР 15141,
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 5-Р ХОРОО, САМБУУГИЙН ГУДАМЖ
МН ТАУЭР, 8-Р ДАВХАР
WWW.MNCA.MN

Хууль эрх зүй:

- МБҮА ТББ-ын Орон нутаг дахь салбар байгуулах журмын төсөл, МБҮА ТББ-ын Гишүүнчлэлийн журамд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл-ийг боловсруулж 2025.02.04-ний өдөр Ерөнхийлөгчдийн зөвлөлийн хурал, 2025.02.13-ны өдөр Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлууллаа.
- Мэргэжлийн Нэгдсэн Холбооны эрх зүйн байдлын тухай хууль, дагалдах журам, салбарын мэргэжлийн нэгдсэн холбоо байгуулахтай холбоотой Ажлын хэсэг-ийн хурлыг 2025.02.04-ний өдөр зохион байгуулж, Ерөнхийлөгчдийн зөвлөлийн хурал болон УЗХ-д танилцуулсан.
- Мэргэжлийн Нэгдсэн Холбоо байгуулах ажлын хүрээнд сургалтын болон түншлэгчидтэй 2025.02.20-ны өдөр хурал зохион байгуулж, МНХ-ны дүрэм боловсруулах, нэгдсэн холбоог зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж Ажлын хэсгийн ахлагчаар МБҮА ТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн Б.Баасансүрэнг сонголоо.
- ХББОСЯ-д Барилгын ерөнхий хууль, Хот байгуулалтын тухай хууль, Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулиудыг боловсруулах “Ажлын хэсэг”-д орж ажиллахаар болсон.
- ХББОСЯ дээр боловсруулагдаж буй Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийг шинэчлэх ажлын хэсгийн гишүүний хувьд Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн үйл ажиллагааны журам, Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн үйл ажиллагааны журмын төсөлтэй холбоотой асуудлаар ХББОСЯ-ны Дахин төлөвлөлтийн хэлтсийн дарга Н.Энхнаран, Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын удирдлагуудтай уулзалт хийж саналаа илэрхийллээ.

Салбарын бодлого, байгууллагын хөгжил:


- МБҮА ТББ-ын дэргэд Барилга, Дэд Бүтцийн Арбитрыг байгуулах ажлын хэрэгжилтийг эрчимжүүлэх, ажлын явцын мэдээллийг 2025.02.04-ний өдөр Ерөнхийлөгчдийн зөвлөлийн хуралд, 2025.02.13-ны өдөр Удирдах зөвлөлийн хуралд танилцуулж, Легал линк ХХК-тай байгуулсан гэрээг дүгнэх, үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг батлахаар шийдвэрлэлээ.
- ФИДИК-ийн гэрээнд шилжих ажлын хүрээнд “Улаан ном”-ын орчуулгын ажлын явцыг Ерөнхийлөгчдийн зөвлөлийн хурал, Удирдах зөвлөлийн хуралд танилцуулж, хурлаас үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг баталж, Фидик ба сургалт, хөгжлийн хороо байгуулах тухай 25/03 тоот тогтоол гаргалаа.

Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл:

- Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн журмыг шинэчлэх “Ажлын хэсэг”-ийн 4 удаагийн хуралд 2025.02.04-10-ны өдрүүдэд оролцож, холбогдох саналуудыг тусган ажилласан бөгөөд Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн суурь нөхцөл шаардлагыг шинэчлэн, иргэн, аж ахуйн нэгжүүдэд дарамтгүй, шаардлагыг эрс хөнгөвчлөн 2025.02.10-ны өдрийн ХББОСЯ-ны 36 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан.
- Шинэчилсэн суурь нөхцөл шаардлагын дагуу цахим программыг шинэчлэх, өөрчлөлт оруулах асуудлаар 2025.02.17-18-ны өдрүүдэд БХТ ТӨААТҮГ, Интерактив ХХК-тай уулзалт хийж тусгай зөвшөөрлийн цахим программыг шинэчлэхээр болсон.

Судалгааны ажлын чиглэлээр:

- “Барилга угсралт, их засварын ажил – 2024 онд” мэдээлэл бэлтгэн барилга.мн сэтгүүлийн буланд өгөхөөс гадна “Их барилга-тооны хэлээр” видео контентыг эхлүүлээд байна.
- Агаар сэлгэлтийн системийн үнэ, угсралтын зардал, шинэ орон сууцны үнийн мэдээлэл, Ундны усны ISO стандарт судалгааг бэлтгэн МБҮА ТББ-ын нийт гишүүдэд хүргэсэн.



Салбарын бодлого, төлөвлөлтийн чиглэлээр:


- Стандарт хэмжил зүйн газарт барилгын стандартчиллын техникийн хорооны гишүүнд нэр дэвшүүлэх саналыг хүргүүллээ.
- Барилгын компаниудыг эрэмбэлэх ажлын хүрээнд БНСУ, Япон, БНХАУ, ОХУ, ХБНГУ, Сингапур, Малайз гэсэн 7 улсын болон дэлхийн барилгын компаниудын эрэмбэлдэг Engineering News-Record (ENR) байгууллагын туршлага, мэдээллийг судлан орчуулж бэлтгэж, МБҮА ТББ-аас барилгын компаниудыг эрэмбэлэхэд ашиглах шалгуур үзүүлэлтийн саналыг бэлтгэн танилцууллаа.
- МБҮА ТББ, Монголын Логистикийн Холбоо ТББ-тай барилгын материалын логистикийн төв байгуулах чиглэлээр хамтран ажиллаж байгаа бөгөөд Засгийн газарт танилцуулах танилцуулгад орох мега төслүүдэд шаардлагатай барилгын гол нэр төрлийн материалын хэрэгцээний тооцоог хийж, цементийн үнийн мэдээлэл бэлтгэв.

МНХ-ны тухай хууль хэрэгжүүлэх бэлтгэл хангах “Ажлын хэсэг”-ийн хүрээнд:



- Ажлын хэсгийн хурлыг зохион байгуулан хуралдуулж, хурлын хөтөлбөр, танилцуулах материал бэлтгэн хурлын тэмдэглэл хөтөлж ажлын хэсгийн гишүүдийг мэдээллээр хангаж ажилласан.
- Бэлтгэл ажлыг хангах хүрээнд ТББ-ын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2-т заасны дагуу улсын бүртгэлийн байгууллагад тайлангаа гаргаж өгсөн барилгын салбарт хамааралтай Төрийн бус байгууллагууд (ТББ)-ын жагсаалтыг гаргуулан авахаар УБЕГ, ТЕГ, НДЕГ-т албан тоот хүргүүлэв.
- МБҮА ТББ-ын УЗХ-д танилцуулах ажлын хэсгийн гүйцэтгэсэн ажлын мэдээллийг бэлтгэн Ажлын хэсгийн ахлагч Б.Баасансүрэнд хүргүүлсэн.

2025



БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР 15141,
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 5-Р ХОРОО, САМБУУГИЙН ГУДАМЖ
МН ТАУЭР, 8-Р ДАВХАР
WWW.MCIS.GOV.MN

БАРИЛГЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХТОЙ ХОЛБООТОЙ ШАТ ДАМЖЛАГЫГ БУУРУУЛАХ ТАЛААР ТАЙЛБАР ХИЙЛЭЭ.



2018 оноос эхлэн төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ, Барилгын Материал Үйлдвэрлэгчдийн Холбооноос барилгын материалын үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөл олгодог болсон. Гэсэн ч барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг авахын тулд маш олон шат дамжлагыг дамжих шаардлагатай тулгарч байгаа тул БАРИЛГЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХТОЙ ХОЛБООТОЙ ШАТ ДАМЖЛАГЫГ БУУРУУЛАХААР ажиллаж байгаа талаар МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх мэдээлэл өглөө.

БАРИЛГЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХТОЙ ХОЛБООТОЙ ШАТ ДАМЖЛАГЫГ БУУРУУЛАХААР АЖИЛЛАЖ БАЙНА










Өнөөдөр “Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн журам, суурь нөхцөл шаардлагад оруулж буй өөрчлөлт, шинэчлэлт” олон нийтийн хэлэлцүүлэг болж, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргыг түр орлон гүйцэтгэгч С.Төмөрхүү, Барилгын материалын хэлтсийн дарга Д.Батзориг, Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ-ийн Гүйцэтгэх захирал Г.Батсүх нар оролцож мэдээлэл хүргэлээ.

Тус хэлэлцүүлгээр Барилгын ерөнхий хуулийн (Шинэчилсэн найруулга)-ын төсөл, Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагад оруулж буй өөрчлөлт, шинэчлэлтийн талаарх мэдээллийг хүргэж, “Барилгын хөгжлийн төв” ТӨҮГ-ын удирдлага, албан хаагчид болон төрийн бус байгууллагууд, иргэд, аж ахуйн нэгжийн төлөөллүүд оролцож санал солилцлоо. Барилгын салбарын нэг онцлог нь 2018 оноос эхлэн төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ, Барилгын Материал Үйлдвэрлэгчдийн Холбооноос барилгын материалын үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөл олгодог болсон. Гэсэн ч Барилгын материалын болон барилга угсралт, барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг авахын тулд маш олон шат дамжлагыг дамжих шаардлагатай тулгарч байна.

Бичиг баримтуудыг цахимаар илгээдэг ч цаана нь боловсруулалт хийхдээ үйл явц нь хүний гараар дамждаг. Тухайлбал: Монголын Барилгын Үндэсний Ассоциаци ТББ цахимаар ирсэн бичиг баримтыг хүлээж аваад 7 хоногийн дотор хариу өгнө, ИТА ажилтан давхцалтай бол БХТ ТӨҮГ-руу хандаж давхцалыг арилгах хүсэлтийг хүргүүлж, давхацсан компаниасаа ажлаас халагдсан тушаал авч хасалт хийлгэн БХТ- ТӨҮГ руу дахин хүргүүлээд давхцалыг арилгуулаад МБҮА ТББ руу хандаж баталгаажуулсаны дараа яам руу бичгээр саналаа илгээдэг. Ирсэн хүсэлтийг яамны мэргэжилтэн, газрын дарга нар хянаад, сайдын тушаал гаргадаг. Гаргасан тушаалын дагуу гэрчилгээн дээр бичилт хийгээд яам руу хүргүүлээд, сайд гарын үсэг зурж баталгаажуулаад МБҮА ТББ руу хүргүүлдэг. Үүний дараа ААН-тэй гэрээ байгуулж тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгодог. Гэрээний дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллага нь БХТ ТӨҮГ-т тайлангаа өгдөг.

ХББОС-ын сайдын 2025 оны 2 сарын 10-ны 55 тоот тушаалаар 2021 оны БХБ-ын сайдын 147, 225 тоот тушаалууд хүчингүй болж өмнөх Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн журам, суурь нөхцөл шаардлага хүчингүй болж байна.
Иймд нэн яаралтай Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн суурь нөхцөл шаардлагыг шинэчлэн баталж тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл байдал үүсэж байна. Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авахад МБҮА-БХТ-ХББОСЯ-МБҮА-БХТ гэсэн ойлгомжгүй төөрөгдөлд орохоор шат дамжлагыг бууруулж аж ахуйн нэгж байгууллагуудад ойлгомжтой, тодорхой, хялбар болгох нэн шаардлагатай байна.

БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ ШААРДЛАГЫГ ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛЖ, БАТАЛЖ БАЙГАА БӨГӨӨД ДАРААХ ӨӨРЧЛӨЛТҮҮДИЙГ ТУСГАЛАА



Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, хууль давсан журмуудыг цуцлах ажлын хүрээнд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд тушаал гаргаж дараах хоёр журмыг цуцаллаа. Эдгээр нь Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийг аж ахуй нэгж, байгууллагад олгох, түүнд хяналт тавих, мөн Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журмууд юм. Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хүчингүй болгосон журам нь 11 зүйл, 116 заалттай байсан бол Зөвшөөрлийн тухай хууль болон Барилгын тухай хуульд байсан заалтуудыг хассанаар 3 зүйл 10 гаруй заалттай цомхон шаардлагатай болсон. Мөн хуульд байхгүй зарим шаардлагыг хүчингүй болголоо. Тухайлбал, Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх шаардлагыг цуцлав. Хүний нөөцийн хомсдолоос шалтгаалан Монгол Улсын зөвлөх инженер 4 компанид, мэргэшсэн инженерийг 2 компанид бүртгэлтэй байж болох зохицуулалт хийсэн. Бусад салбарын зөвлөх, мэргэшсэн зэрэгтэй инженерийг барилгын салбарын зөвлөх зэрэгт дүйцүүлэн тооцно. Инженер техникийн ажилтны шилжилт хөдөлгөөн хийсэн тохиолдолд 30 хоногийн дотор нөхөж бүртгүүлнэ гэснийг 90 хоног болгосон. Хос мэргэжилтэй салбарын инженер, техникийн ажилтан нь нэг компанид хос мэргэжлээ ашиглах, тухайн мэргэжил тус бүрээр байгууллагуудад бүртгэлтэй байж болно. Гадаадын хуулийн этгээдийг дэмжих үүднээс Олон Улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /OECD/-ын гишүүн 38 улсын аж ахуйн нэгж, байгууллагуудын болон ОХУ, БНХАУ, БНЭУ-ын инженер техникийн ажилчдын мэргэжлийн дипломыг дүйцүүлэн тооцно. Компаниудын нэгдэл буюу групп компани нь тусгай зөвшөөрөл авах шаардлага үүссэн тохиолдолд өөрийн охин буюу салбар аж ахуйн нэгж, байгууллагын инженер, техникийн ажилчдын мэдээллийг ашиглан тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангуулж болно. Тухайн аж ахуй нэгж байгууллагын захирал гэрээ байгуулахын өмнө гүйцэтгэх удирдлагын 1 багц сургалтад хамрагдсан байх. Тухайлсан барилгын зөвшөөрлийг компанид биш тухайн төсөлд олгохоор боллоо. Мөн барилгын салбарт олгож байгаа 126 төрлийн зөвшөөрлийг 84 нэр төрөл болгож бууруулах юм. Барилгын материалын үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг авахад голлон Тохирлын гэрчилгээнд үндэслэн цахимаар хялбар олгодог болох зохицуулалт хийлээ.

БҮАТЗХ-ИЙН “НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ”-ИЙН 2025.02-Р САРЫН ТОЙМ


БҮАТЗ-ийн хэлтэс нь “Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр дамжуулан 600 гаруй ААНБ, иргэдийг тухай бүр нь мэдээллээр ханган ажиллав.






БҮАТЗ-тэй холбоотой “Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, тэдгээрт хяналтыг тавих, барилгын үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудад тавих шаардлага, бүртгэх журам”-ын дагуу барилгын тусгай зөвшөөрлийг хүссэн 140 ААНБ-ын хүсэлт, материалыг баталгаажуулж, ХББОСЯ-нд 2025.02.06, 2025.02.12, 2025.02.27-ны өдрүүдэд тус тус цахимаар илгээв.

Барилгын тусгай зөвшөөрөл хүссэн ААНБ-уудын хүсэлтийн баталгаажуулалт





Тайлангийн хугацаанд давхардсан тоогоор 369 ААНБ-ын хүсэлт хянагдаж, 3 удаагийн БАТАЛГААЖУУЛАЛТ-аар 140 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулав.

Үүнээс: Сунгалтаар 6, Нэмэлтээр 33, Шинээр 101 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулав. Сунгалтаар 6 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулснаас: Барилга угсралтаар 4, Зураг төсөл боловсруулалтаар 1, Нэмэлтээр 33 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулснаас: Барилга угсралтаар 26, Зураг төсөл боловсруулалтаар 7, Шинээр 101 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулснаас: Барилга угсралтаар 87, Зураг төсөл боловсруулалтаар 13, Өргөх байгууламжаар 1 ААНБ-ын хүсэлтийг баталгаажуулав. Эдгээр 3 удаагийн хурлаар давхардсан тоогоор 198 ААНБ-ын материалыг шаардлага хангаагүйн улмаас буцааж, 54 ААНБ-ын хүсэлтийг шалгахаар хүлээгдэж байна.

- Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах, барилгын ажлыг гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар, үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, тэдгээрт хяналтыг тавих, барилгын үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагад тавих шаардлага, бүртгэх журам”-ын дагуу тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт ирүүлсэн 140 ААНБ-ын хүсэлтийн материалыг хянаж, 676 инженер, техникийн ажилтнуудын баталгаажуулалтыг хийв.
- Монгол Улсын Засгийн газрын “Нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал”-д нийтлэх БҮАТЗ-ийг эзэмшигч хуулийн этгээдийн мэдээллийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гаргаж, 2 удаа ХББОСЯ-нд хүргүүлэв. Улсын бүртгэлийн ерөнхий газрын *opendata.burtgel.gov.mn*-д БУ: 4,351, ЗТ: 871, ӨБ: 157 ААНБ-ын нийт 5,379 ААНБ-ын мэдээллийг нээлттэй байршуулав.
- БҮАТЗ-тэй ААНБ-уудын мэдээллийн санг үүсгэн *www.mcis.gov.mn*-ын “Холбогдох бичиг баримт хэсэг”-т БУ: 4,351, ЗТ: 871, ӨБ: 157 ААНБ-ын нийт 5,379 ААНБ-ын мэдээллийг нээлттэй байршуулав.
- Цахим Хөгжил, Харилцаа Холбооны Яам (ЦХХХЯ)-ны тусгай зөвшөөрлийн цахим системд БУ: 118, ЗТ: 20, ӨБ-3 ААНБ-ын мэдээллийг илгээв.
- ХББОС-ын Сайдын тушаалыг үндэслэн 140 ААНБ-тай гэрээг байгуулж, Засгийн газрын “Улсын тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг тогтоох” тогтоолын дагуу 141,900,000 төгрөгийн Улсын тэмдэгтийн хураамжийг Худалдаа, хөгжлийн банкны дансанд төвлөрүүлэв.
- Үйлчилгээний хөлсний 140 ААНБ-ын 82,730,000 төгрөгийг Худалдаа, хөгжлийн банкны 431006029 тоот дансаар төвлөрүүлэн ажиллав.

ХББОС-ын Сайдын 2025.02.07-ны өдрийн тушаал №32, №34 дүгээр тушаалыг үндэслэн 141 ширхэг үнэт цаасанд бичилтийг хийж, баталгаажуулав.

2025

ГИШҮҮНЧЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА



МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР 15141,
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 5-Р ХОРОО, САМБУУГИЙН ГУДАМЖ
МН ТАУЭР, 8-Р ДАВХАР
WWW.MNCA.MN

МБҮА ТББ-Д ГИШҮҮН БАЙГУУЛЛАГААР ЭЛССЭН БАЙГУУЛЛАГУУДАА ЁСЧИЛЛОО



- МБҮА ТББ-ын Гишүүнчлэлийнхээ тоог нэмж, үйл ажиллагааныхаа цар хүрээг тэлэх зорилт, 2025 онд хэрэгжүүлэх Гишүүнчлэлийн мега төслийн хүрээнд гишүүнчлэлийн бүтээгдэхүүн үйлчилгээг олон нийтэд таниулан хүргэхээр мэдээлэл постер бэлтгэн холбогдох мэдээ мэдээллийг өгч ажилласны үр дүнд 2025.02-р сард Гишүүнээр барилга угсралт, барилгын материал худалдаа, үйлдвэрлэлийн АЯГА-УУЛ ХХК, ЧИН ОВОО ХХК, МӨНХ ТАВАН ХОТ ХХК, ЖУН ЛАНГ ДООР ВИНДӨВ ТРАЙД ХХК (Jun Lang Door Window Trend LLC) болон ДЕЛИТАЙ ЦАХИЛГААН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ХХК, Дэмжигч гишүүнээр ШУТИС-ийн геотехникийн судалгааны төвийн захирал С.НЯМДОРЖ нь гишүүнээр элссэн бай шинээр элссэн гишүүн байгууллагуудад Гэрчилгээг Удирдах зөвлөлийн хурлын үеэр гардууллаа.



- Мөн МБҮА ТББ-ын Гишүүнчлэлийн гэрчилгээний шинэчилсэн загварын боловсруулан батлуулж, 2025 онд шинээр элссэн орж буй гишүүдэд шинэчилсэн гишүүнчлэлийн гэрчилгээг гардуулж өгч эхлээд байна.Гишүүнчлэлийн тоог нэмэгдүүлэх ажлыг идэвхжүүлэх ажил үргэлжил байна.

МБҮА ТББ НЬ "BUSINESS MEETING & ГИШҮҮДИЙН ЧӨЛӨӨТ УУЛЗАЛТ"-ЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



МБҮА ТББ-ын Гишүүн компаниуд болон "Дулаан шийдэл II" төсөлтэй хамтран ажилладаг барилгын салбарын бизнес эрхлэгчдийн хооронд бизнесийн холбоо тогтоох боломжийг олгох, салбарын өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлагын талаарх ярилцан, харилцан байр сууриа солилцох, талуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, өргөжүүлэх хүрээнд 2025.02.05-ны өдөр "BUSNESS MEETING & ГИШҮҮДИЙН ЧӨЛӨӨТ УУЛЗАЛТ"-ыг зохион байгууллаа.

Тус уулзалтад Гишүүн компаниуд болон дулаан шийдэл төслөөр чадавхжиж буй бригадуудын төлөөллүүд идэвхтэй оролцлоо. Уулзалтаар салбарын ААНБ, бизнес эрхлэгчдэд Хот байгуулалт,

барилга, орон сууцжуулалтын яамны бодлого, өөрчлөлт, шинэчлэлт хийж байгаа хууль болоод шинээр боловсруулж байгаа хуулийн төслүүд, норм дүрэм, журмуудад ямар өөрчлөлт оруулж байгаа талаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Төмөрхүү танилцуулахаас гадна, Бид салбартаа ямар хувь нэмэр оруулж чадах вэ?" багаар ажиллах & байр сууриа солилцох сэдвийн хүрээнд оролцогчид идэвхтэй багаар ажиллуулж энэ удаагийн чөлөөт уулзалт амжилттай болж өнгөрлөө. "Бизнес нетворкинг чөлөөт арга хэмжээ"-д МБҮА ТББ-ын гишүүн 18 байгууллагын 26 хүнийг хамруулав. Үүнд: БХЯ-ны Барилга захиалагчийн алба, Бульдорс Мон ХХК, Топпродакт ХХК, Эн Си Ди групп ХХК, Скэч ХХК, Бодь Интернэшнл ХХК, Роял нью кэстл ХХК, Оффис Партнер ХХК, Жи ар прикаст ХХК, Добу технологи ХХК, И си си ХХК, Бодь Пропертийз ХХК, Монгол базальт ХК, Эрчим инженеринг ХХК, Макс өргөө ХХК, Сүндэр өргөө трейд ХХК, Дабль пирамид ХХК, Улз буянт пропертийз ХХК хамрагдлаа.

МОНГОЛЫН ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХӨГЖЛИЙН ТАНХИМ (МХБХТ)-ААС ЖИЛ БҮР УЛАМЖЛАЛ БОЛГОН "ШИЛДЭГ БАРИЛГА-2025" ШАЛГАРУУЛЛАА

Энэ удаагийн "Шилдэг Барилга" шалгаруулалтад Монгол Улсын нийслэл хот, аймаг орон нутгийн хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулсаар ирсэн их бүтээн байгуулалтын салбарын хөрөнгө оруулагч, гүйцэтгэгчид оролцож байгаа бөгөөд шилдэг хөрөнгө оруулагч, гүйцэтгэгч, архитектор, хот төлөвлөгч, барилгын инженер техникийн ажилтнуудын мэргэжлийн ур чадвар шингэсэн олон барилга байгууламжууд нэр дэвшин өрсөлдсөнөөс Шилдэгийн Шилдэг барилга-1, "Шилдэг Барилга" өргөмжлөлийг 12 барилгын хөрөнгө оруулагч, гүйцэтгэгч байгууллагууд гардан авжээ. 🏆 Үүнд МБҮА ТББ-ын дараах гишүүн байгууллагууд ШИЛДЭГ БАРИЛГА-аар шалгарсанд ШИЛДГҮҮДДЭЭ БАЯР ХҮРГЭЕ 👏👏







"БАРИЛГЫН САЛБАР ДАХЬ МАНЛАЙЛАЛ БА ШИНЭЧЛЭЛ" АРГА ХЭМЖЭЭНД МБҮА ТББ ОРОЛЦЛОО

"Нийслэлийн шинэ бүтээн байгуулалтын төслүүдтэй танилцах, барилгын шинэ дэвшилтэт техник, технологийн мэдээллийг солилцох, харилцан ашигтай шийдлийг олох, ААН-үүд төсөл хөтөлбөрүүдийг хамтран хэрэгжүүлэх, барилгын материал үйлдвэрлэгчид, ханган нийлүүлэгчид бараа, бүтээгдэхүүнээ танилцуулах, бизнесийн харилцаа тогтоох гэх мэт ач холбогдолтой нийслэл хотын барилга, бүтээн байгуулалт бизнес уулзалт-д МБҮА ТББ-ын Гүйцэтгэх захирал Г.Батсүх "БАРИЛГЫН САЛБАР ДАХЬ МАНЛАЙЛАЛ БА ШИНЭЧЛЭЛ" сэдвээр итгэл тавьсан бөгөөд тус илтгэл тайлантай холбоотойгоор холбогдох мэдээллийг бэлтгэв.










Байгууллагын нийт гишүүн байгууллагуудын мэдээллийн санг хялбар үүсгэх, хайж олох, харилцсан түүхийг тэмдэглэх боломжтой болгох зорилгоор програм хангамжийн Грийнсофт ХХК-тай хамтран тус компанийн CRM программыг нэвтрүүлж эхлээд байна. Энэхүү ажлын хүрээнд тус программын ашиглалт, хэрэглээний талаарх тодорхой мэдээлэл авахаар Грийнсофт ХХК-ийн төлөөлөлтэй хийх цахим уулзалтыг 2025.02.20-ны өдөр зохион байгуулан ажиллав. Мөн түүнчлэн, www.mnca.mn сайтын ажиллагаанд оруулсантай холбогдуулан тус сайтад гишүүн байгууллагуудын бүртгэлжүүлэх ажлыг хийж эхлээд байна. CRM дээр гишүүн байгууллагуудыг бүртгэл хийж нийт 100 гаруй бүртгэлийг EXCEL файлаас хуулан шивлээ. Гишүүнчлэлтэй холбоотой холбогдох мэдээ мэдээллүүдийг цаг тухай бүрт нь CRM дээр бүртгэлжүүлж хэвшив. CRM, call center, easy call, massmail, mass massage үйлчилгээнүүдийн ашиглалтыг хэвшүүлж, хэрэглээ болгох тал дээр анхааран ажиллав.



Нийт гишүүдэд зориулсан 2025 оныг дүүсталх Гишүүдэд зориулсан энэ жилийн онцлох арга хэмжээ, хийгдэх ажлуудын хүрээнд Календарчилсан Төлөвлөгөө боловсруулж танилцуулагдахад бэлэн боллоо.

<u>Гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр:</u>



- Гадаад харилцаа, хамтын ажиллагаатай холбоотой өдөр тутмын захидал харилцааны foreign_relations@mnca.mn хаягаар ирсэн 6 цахим шууданг орчуулан удирдлагад танилцуулж, 6 захидлыг гадагшаа илгээлээ. Үүнд: IFAWPCA, WEBINAR, FIDIC, CHINCA зэрэг байгууллагуудтай хамтын ажиллагааны тухай хэлэлцэж, мэдээллийн чанартай зүйлсийг зохион гишүүн байгууллагууддаа хүргэн ажиллалаа.
- IFAWPCA-гаас Webiner зарласан ба тус онлайнаар зохион байгуулагдсан уулзалтын мэдээллийг орчуулан бэлтгэж, орчуулга болон постер зургуудыг бэлтгэн ГИШҮҮДДЭЭ нийт гишүүддээ мэдээлэл хүргэв.
- ФИДИК-ээс Гэрээг хэрэгжүүлэх, Монголд сурталчлах, түгээхийг дэмжиж, талархан хүлээж авч байгаагаа дурдсан мэдээлэл ирлээ.
- IFAWPCA-гийн 47-р их хуралд оролцох МБҮА ТББ-ын Ерөнхийлөгчийн нислэгийн тийз, буудлын захиалгыг хийж, бүртгэлийн хураамж, төлбөрийг шилжүүлж, баталгаажууллаа.
- Бангладешийн Барилгын Салбарын Холбоо (ББСХ) ТББ, Филиппиний Барилгачдын Ассоциаци (ФБА) ТББ-тай байгуулсан “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийн шинэчилсэн төслийг бэлтгэн МБҮА ТББ-ын Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал нарт танилцуулахаар хүргүүлсэн.

2025

“ДУЛААН ШИЙДЭЛ2" ТӨСӨЛ



МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР 15141,
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, 5-Р ХОРОО, САМБУУГИЙН ГУДАМЖ
МН ТАУЭР, 8-Р ДАВХАР
WWW.DULAALGA.MN

БОДЬ ПРОПЕРТИЙЗ" ХХК-ИЙН САНХҮҮЖИЛТЭЭР 2 АЙЛ ӨРХИЙН БАЙШИНГ БҮТЭН ДУЛААЛЖ, ХҮЛЭЭЛГЭН ӨГЛӨӨ

"Бодь Пропертийз" ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд МБҮА ТББ-ын хамтран хэрэгжүүлж буй "Дулаан шийдэл II" төсөлд 2 айл өрхийн байшинг бүтэн дулаалах санхүүжилт олгосон. Ингэхдээ Улаанбаатар хотын байшинтай өрхүүдийн дунд нээлттэй шалгаруулалт зарлаж, 12 шалгуур үзүүлэлтээс хамгийн өндөр үнэлгээ авсан СХД-ийн 22-р хорооны иргэн Г.Хүрэлбаатар болон СХД-ийн 7-р хорооны иргэн Б.Үрлээгийн байшинг тус тус бүтэн дулаалахаар сонгосон юм. Тус хоёр байшингийн хана, дээвэр, суурь дулаалах, хаалга, цонх солих ажлыг "Дулаан шийдэл II" төсөлд хамрагдаж, дулаалгын технологид суралцсан Ц.Пүрэв, Ц.Цогт-Эрдэнэ ахлагчтай барилгын бичил, жижиг бизнес эрхлэгчид 2025.02.04-18-ны хооронд хийж гүйцэтгэлээ. Байшинг технологийн дагуу зөв, бүрэн дулаалснаар тухайн айл өрхөд 50 ба түүнээс дээш хувийн эрчим хүчний хэмнэлт үүсэж, тэр хэрээр түлш зарцуулалт багасан, өрхийн эдийн засагт эергээр нөлөөлөх, дотор агаарын чанар сайжрах зэрэг боломж бүрдлээ. Ийнхүү 2025.02.18-нд дулаалгын ажлын үр дүнг айл өрхүүдэд Бодь Пропертийз ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Тэгшбаяр, МБҮА ТББ-ын гүйцэтгэх захирал Г.Батсүх нар хүлээлгэн өгөв. Тус хоёр байшинг дулаалахын өмнө “Дулаан шийдэл II” төслөөс дулаан алдагдлыг илрүүлэх зорилгоор камертай хэмжилт хийж, дулааны тав тух болон дотор агаарын чанарыг хэмжихээр өвлийн хэмжилтийн багаж суурилуулаад байна. Мөн сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж суурилуулна. Ийнхүү тодорхой хугацааны дараа үр дүнг хэмжих, мэдээлэх, эрчим хүчний хэмнэлтийн гэрчилгээ гаргах зэрэг ажлыг үргэлжлүүлэн хийж гүйцэтгэнэ.



СХД-ийн 22-р хороонд оршин суугч Г.Хүрэлбаатарынхыг дулаалахын өмнө: 2025.02.04



СХД-ийн 22-р хороонд оршин суугч Г.Хүрэлбаатарынд хийж буй дулаалгын ажлын явц






СХД-ийн 7-р хороонд оршин суугч Б.Үрлээгийнд дулаалахын өмнө: 2025.02.04






СОНГОГДСОН 2 АЙЛД СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ СУУРИЛУУЛАЛТЫН ТАЛААРХ ОНЛАЙН УУЛЗАЛТ ХИЙЛЭЭ

Нийт 22 айл өрх материалаа ирүүлснээс эхний шалгуурыг 10 өрх хангасан байсан ба шалгуур хангасан 10 айл өрхөд камертай хэмжилт хийж 3 айлыг богино жагсаалтад оруулж эцсийн байдлаар технологийн дагуу дулаалах боломжтой 2 өрхийг шалгаруулсан. Сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж суурилуулах тул наран талд байршсан айл өрхийг сонгосон. 12 шалгуур үзүүлэлтийн дагуу шалгаруулж сонгов.





“БИД САЛБАРТАА ЯМАР ХУВЬ НЭМЭР ОРУУЛЖ ЧАДАХ ВЭ?” СЭДВИЙН ХҮРЭЭНД БАГААР АЖИЛЛАН БАЙР СУУРИА СОЛИЛЦЛОО



МБҮА ТББ-ын гишүүн компаниуд болон "Дулаан шийдэл II" төсөлтэй хамтран ажилладаг барилгын салбарын бизнес эрхлэгчдийн хооронд бизнесийн холбоо тогтоох, харилцан байр суурια солилцох, талуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, өргөжүүлэх зэрэг нөхцөл, боломжийг бүрдүүлэх мөн салбарын ААНБ, бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр арга хэмжээ зохион байгууллаа. Арга хэмжээнд оролцогчдыг 6 багт хуваан сэдэв өгч, тухайн сэдвийн хүрээнд төсөл боловсруулж, багаараа боловсруулсан төслөө танилцуулан, нийт оролцогчдын нээлттэй саналаар “НАРЛАГ МОНГОЛ” төсөл шилдэг төсөл боловсруулсан багийг шалгаруулав.

"ДУЛААН ШИЙДЭЛ-II" ТӨСЛИЙН ШИЛДЭГ ГҮЙЦЭТГЭГЧДИЙГ УРАМШУУЛЛАА







“Дулаан шийдэл II” төсөлтэй хамтран ажилладаг бизнес эрхлэгчдээс 2024.06-2024.11-р сарыг дуусталх ажлын гүйцэтгэлийн үнэлгээгээр тэргүүлсэн шилдэг 5-н гүйцэтгэгч буюу Дулаалгын зөвлөх, Топ мастер ХХК-ийн захирал, МБҮА ТББ-ын дэд гишүүн Ш.Баярсайхан, Ц.Гаябазар, Т.Базар, Ж.Есүхэй, Ц.Цогт-Эрдэнэ нар шалгарлаа.

НИЙТ ОРОЛЦОГЧДЫН ДУНДААС 4 АЗТАН ТОДРУУЛАВ






АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРОО БОЛОН ДУЛААН ШИЙДЭЛ II ТӨСӨЛТЭЙ ХАМТРАН 2 АЙЛД КАМЕРТАЙ ХЭМЖИЛТ ХИЙЛЭЭ





Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооноос иргэдийн байшингийн дулаан алдагдлыг илрүүлж, хэмжүүлэхийн ач холбогдлыг тайлбарлан таниулах ажилд “Дулаан шийдэл II” төсөлтэй хамтран ажиллах хүсэлтээ ирүүлсний дагуу 2025.02.13-ны өдөр Гандан орчмын 2 айлд камертай хэмжилт хийж, тус айл өрхүүдэд зөвлөгөө өгөх замаар мэдээлэл бэлтгэх зураг авалтад манай төслийн дулаалгын зөвлөх Ч.Сумъяабат оролцов. Дэлгэрэнгүй мэдээлэлтэй доорх линкээр танилцана уу. https://www.facebook.com/share/p/199VRv8bQC/ https://fb.watch/xTR4SBl2th/

БАРИЛГЫН САЛБАРЫН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ БАГЦ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД 4 ТӨРЛИЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЖ, 96 ХҮНИЙГ ХАМРУУЛАВ

“БАРИЛГЫН ДУЛААН ХАМГААЛАЛТЫН ҮНЭЛГЭЭ-ДУЛААНЫ КАМЕРТАЙ ХЭМЖИЛТИЙН” ОНЛАЙН СУРГАЛТ





Барилга, байшинд дулааны камераар хийх хяналт, оношилгоо, дулааны камертай хэмжилт хийх барилга, байшинд тавигдах шаардлага, дулааны камераар барилга, байшингийн гадна, дотор талаас дулааны зураг авах цэгүүдийн талаар мэдлэг мэдээлэл олголоо. Тус онлайн сургалтад МБҮА ТББ-ын гишүүн 5 байгууллагын Ш.Баярсайхан, Топ мастер ХХК, Мөнх-Өргөө ХХК, Номин констракшн девелопмент ХХК, Монгол базальт ХК-ийг хамруулав.

ДАРХАН ХОТ ДАХЬ "ДУЛААНЫ КАМЕРТАЙ ХЭМЖИЛТИЙН НЭГДСЭН ДАДЛАГА СУРГУУЛИЛТ" БОЛЛОО






Дадлага сургуулилтын үеэр оролцогчид тус аймгийн Дархан сумын 15-р баг, 9-р хэсэг (Биатлон)-т хувийн сууцыг гадна болон дотор талд нь камертай хэмжилт хийв. Үүний дараа байшингийн хаагуур дулаан алдаж байгаа талаар болон ямар дулаалга хийх шаардлагатай тухай хамтран хэлэлцэж, дүгнэлт гаргасан юм.

ДАРХАН- УУЛ АЙМАГТ ДУЛААНЫ КАМЕР ОЛГОЛОО



Дархан-Уул Аймгийн ЗДТГ, Дархан-Уул Аймгийн Дахин Төлөвлөлтийн Газар ААТҮГ, Жэрэс ОУТББ-ын хооронд 2024 оны 7 сард байгуулсан гуравласан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд Дулаан Шийдэл төслийн хүрээнд хийгдэж буй үйл ажиллагаа болон цаашид төлөвлөж буй ажлуудын талаар мэдээлэл солилцох зорилготой онлайн уулзалт хийгдлээ. Үүний хүрээнд Дархан-Уул аймгийн дулаалгын зөвлөхүүдийг камертай хэмжилт хийх боломжоор хангах үүднээс Дархан дахин төлөвлөлт ОНӨААТҮГ-т дулааны камер олголоо. Ингэснээр тус аймагт Дулааны камертай хэмжилт хийх бүрэн боломжтой болж байна. Дэлгэрэнгүй мэдээлэлтэй доорх линкээр орж танилцана уу.
https://www.facebook.com/share/p/16Jd8bYTeV/

DULAALGA.MN САЙТ БҮРЭН ШИНЭЧЛЭГДЭЖ, ШИНЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРЛОО



Жэрэс ОУТББ нь IT-ийн Ганхөлгөн ХХК-тай хамтран Dulaalga.mn сайтыг шинээр сайжруулан ашиглалтад оруулахаар төлөвлөсний дагуу 2025.02.14 өдөр сургалт зохион байгууллаа. Шинэ систем хэвийн ашиглалтад орсноор илүү хялбар ашиглах системтэй болж, олон чиглэлээр дулаалгын ажлыг зохион байгуулах, ББЖБЭ-д өөрийгөө сурталчлан таниулах, захиалга хүлээн авах боломж бүрдэх бөгөөд 2025.02.24-ний өдөр дахин сургалт зохион байгууллаа.

СУРГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

УЛААНБААТАР ХОТ ДАХЬ "ДУЛААНЫ КАМЕРТАЙ ХЭМЖИЛТИЙН НЭГДСЭН ДАДЛАГА СУРГУУЛИЛТ"






“НИЙТ АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН ХАБЭА-Н” СУРГАЛТ:

ХАБЭА-ийн тухай ойлголт, хамаарах асуудал, хөдөлмөрийн гэрээ мөрдөгдөж буй хууль тогтоомж, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний тухай ойлголт, даатгал, тусламж, үйлчилгээ мөн ажилтан гэлтгүй иргэн бүр өөрийн ажлын байран дахь эрсдэлээ өөрөө зөв үнэлэх, хариуцлагатай, ухамсартай байх, эрсдэл үүссэн тохиолдолд авах боломжит хариу арга хэмжээний талаарх мэдээлэл гэх мэт

"Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй"-тай холбогдох хуулиуд болон ХЭМАБ-ын удирдлагын тогтолцоо,шаардлага MNS ISO45001:2018 стандарттай доорх холбоосоор орж танилцана уу.

https://legalinfo.mn/mn/detail?lawId=564
https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230709635751
https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760148705641
https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760148505951
https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760148379551
https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760148638921
https://resource4.sodonsolution.org/mongolros/File/2023/05/04/jyy8nr325kdsrvxs/ISO%2045001n.pdf





"УДИРДАХ АЖИЛТНЫ ХАБЭА-Н" СУРГАЛТ



"**Удирдах ажилтны хабэа-н"** сургалтад МБҮА ТББ-ын гишүүн Н Эй Би ХХК, Силвер тауэр ХХК, Максимал ХХК-иас оролцов.https://cdn.greensoft.mn/uploads/users/1104/files/MNS-4969-2000.pdf

СТРЕСС МЕНЕЖМЕНТ СУРГАЛТАД ХАМРАГДЛАА



2025.02.07-ны өдөр Жэрэс ОУТББ-аас Стресс менежмент сургалтыг зохион байгуулав. Сургалтыг Ганабелл Хүрээлэнгийн Сэтгэл судлалын багш н.Гандолгор удирдаж явуулсан бөгөөд нийт Жэрэс ОУТББ-ын менежер, мэргэжилтнүүд болох 7, "Дулаан шийдэл II" төслийн 2 оператор, БЭХХТ-ийн инженер н.Уганбаатар, МБҮА ТББ-ын төслийн ажилтан Б.Минжинсор, төслийн зохицуулагч Б.Солонго нар оролцлоо. Сургалтаар стресс гэж юу болох, эерэг болон сөрөг стресс түүний ялгаа, стресс үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлс, стрессийг хэрхэн зөв удирдах, хувиргах талаар мэдлэг олголоо.

"ДУЛААН ШИЙДЭЛ II" ТӨСЛИЙН БАГИЙН 2025.02-Р САРЫН ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТО

Д/Д	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ТООН ҮЗҮҮЛЭЛТ
1.	ББЖБЭ-дэд зуучилсан техникийн үнэлгээний захиалга	38
2.	Техникийн үнэлгээний захиалгыг хуваарилсан ББЖБЭ-ийн тоо	17
3.	ББЖБЭ-ийн хийж гүйцэтгэсэн техникийн үнэлгээний тоо	19
4.	ББЖБЭ-дэд зуучилсан дулаалгын ажлын тоо	1
5.	ББЖБЭ-дэд зориулан зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо	5
6.	Зохион байгуулсан сургалт, арга хэмжээнд оролцсон ББЖБЭ-ийн тоо	35
7.	Арга зүйн зөвлөмжийг өгсөн ББЖБЭ-ийн тоо	17
8.	Санал, хүсэлт, гомдлыг нь шийдвэрлэсэн харилцагчдын тоо	7



МБҮА
МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ
SINCE 2009

Монгол Улс, Улаанбаатар 15141,
Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Самбуугийн гудамж,
МН Тауэр, 8-р давхар, 805, 806, 811 тоот

7011 1515

info@mnca.mn

www.mnca.mn